



Өнгө заасан
нэрийг сэтгэц
хэлшинжлэлийн
үүднээс судлах нь

О.НАНДИН-ЭРДЭНЭ

ҮНДСЭН АСУУДАЛ

Энэхүү судалгаа монгол, англи хэлний өнгө заасан нэрийг сэтгэц хэлшинжлэлийн үүднээс анх удаа зэрэгцүүлэн судалсан, сэтгэц хэлшинжлэлийн авалцуулан холбох аргыг монгол хэлний өнгө заасан нэрийн судалгаанд анх удаа ашигласан, өнгө заасан нэрийг ХЭЛ- СЭТГЭХҮЙ - ТАНИХУЙ гурамсан холбоонд авч үзсэнээрээ шинэлэг болно.

Орчин цагийн хэлшинжлэл ХҮН төвтэй болсон өнөө үед монгол, англи хэлний өнгө заасан нэрийн баримтаар хийсэн энэхүү судалгаа нь хэл, сэтгэхүй, танихуйн салшгүй холбоог хоёр хэлний баримтаар харуулж, хүний сэтгэхүй, танихуйн суурь шинж хэлний баримтаар илэрнэ гэдгийг батлах оролдлого юм.

СУДАЛГААНЫ ҮНДЭСЛЭЛ

Монгол хэлний өнгө заасан нэрийг сэтгэц хэлшинжлэлийн үүднээс судалж, монголчуудын өнгө заасан нэр үүсгэх сэтгэлгээний хэв шинж, сэтгэх аргыг тогтоосон судалгаа өнөө хэр үгүй байгаа нь энэхүү ажлыг бичих үндэслэл боллоо.

ДЭВШҮҮЛЖ БАЙГАА ҮЗЭЛ САНАА

Зэрэгцүүлсэн судалгаа нь судалж буй хоёр хэлний баримтаар эдгээр хэлээр хэлэлцэгч ард түмнүүдийн танихуйн суурь мэдлэг, үүнд суурилсан сэтгэлгээний хэв шинж, сэтгэх арга, өнгө заасан нэрийн үндэсний онцлогийг тод томруун гаргах боломж олгох юм гэж үзсэн билээ.

СУДАЛГААНЫ ЗОРИЛГО

Монгол, англи хэлний өнгө заасан нэрийг сэтгэц хэлшинжлэлийн үүднээс судалж, өнгө заасан нэр үүсэх сэтгэлзүйн бүтээцтэй аргыг тодорхойлох, зэрэгцүүлж буй монгол, англи хоёр хэлээр хэлэлцэгч ард түмнүүдийн танихуй, соёл, сэтгэлгээний онцлог хэлний баримтаар хэрхэн илэрч буйг тогтооход оршино.

СУДАЛГААНЫ ЗОРИЛТ

- ▶ Төрөл бүрийн эх сурвалжид тулгуурлан монгол, англи хэлний өнгө заасан нэрийн сан бүрдүүлэх;
- ▶ Монгол, англи хэлний өнгө заасан нэр бусад үгтэй холбогдох танихуй ба сэтгэлгээний хэв шинжийг тодорхойлох;
- ▶ Монгол хэлний өнгө заасан нэрийг сэтгэлзүйн авалцуулан холбох аргаар судалж
 - а. монголчуудын өнгө заасан нэр үүсгэх сэтгэлгээний хэв шинжийг **дохио үг** → **хариу үг** загвараар туршилт хийн тогтоох,
 - б. монгол хүний өнгө таних, нэрлэх онцлогийг **дохио өнгө** → **хариу үг** загвараар туршилт хийх

СУДАЛГААНЫ ХЭРЭГЛЭГДЭХҮҮНИЙ ЭХ СУРВАЛЖ

- ▶ Хоёр хэлний тайлбар толь бичиг
- ▶ Уран зохиолын жишээ баримт
- ▶ Аман ярианы баримт
- ▶ Сэтгэгц хэлшинжлэлийн туршилт
 - а. дохио үг → хариу үг загвар
 - б. дохио өнгө → хариу үг загвар

СУДАЛГААНЫ АРГА

- ▶ Сэтгэгц хэлшинжлэлийн авалцуулан холбох туршилтын арга
- ▶ Асуулгын арга
- ▶ Хам бичвэрийн арга
- ▶ Хоёр хэлний баримтыг зэрэгцүүлэх арга
- ▶ Тооцоолох арга
- ▶ Зурагжуулах арга
- ▶ Ажиглах арга
- ▶ Задлан шинжлэх
- ▶ Нэгтгэн дүгнэх

СУДАЛГААНЫ АЖЛЫН АЧ ХОЛБОГДОЛ

Хоёр хэлний өнгө заасан нэрийн хүрээг толь бичиг болон бусад эх сурвалжид суурилан тодорхойлж, өнгө таних, нэрлэх сэтгэлгээний хэв шинж, өнгө заасан нэр үүсэх сэтгэлзүйн аргуудыг тогтоон, танихуйн тайлбар хийж, өнгө заасан нийлэмжийн бүтцийг хэл тус бүрээр тодорхойлон, нийлэмж үүсгэх чадамжийг тодорхойлж, хэрэглэгдэхүүнд түшиглэн хэл, танихуйн туршлага, сэтгэлгээний хэв шинжийн асуудлыг зангидахыг оролдсон.

Бидний судалгааны ажлын нэг чухал бүрэлдэхүүн хэсэг болох сэтгэлзүйн туршилт нь монгол хэлний өнгө заасан нэрийн хүрээ, хэрэглээг тодруулах, баяжуулах ач холбогдолтой.

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

ӨНГӨ СЭТГЭЦ

ХЭЛШИНЖЛЭЛИЙН

СУДЛАХУУН БОЛОХ НЬ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

- ▶ 1.1. Өнгө заасан нэрийн судалгааны тойм
- ▶ 1.2. Өнгөний физик шинж
 - 1.2.1. Өнгө гэж юу вэ? Физикчид өнгөний тухай
 - 1.2.2. Хэл шинжээчид өнгөний тухай
- ▶ 1.3. Өнгө таних биезүйн үндэс
 - 1.3.1. Тархины танихуйн чадвар, үүргийн онцлог, эрэгтэй, эмэгтэй хүний тархи
 - 1.3.2. Харааны биезүйн үндэс

ӨНГӨНИЙ ФИЗИК ШИНЖ

Физикийн шинжлэх ухаанд:

Гэрлийн тусламжтайгаар хүн нүдээр хүртэн мэдэрч буй биетийн нэгэн шинж чанарыг өнгө гэнэ.

(The Physics Hypertext book (www.physics.info))

Хэл шинжлэлд:

Физикийн шинжлэх ухаанд өнгө тодорхойлсныг хүлээж авдаг. Өнгө заасан нэрийн судалгааг хэлний баримтаар хийдэг.

Өнгө заасан нэрийн талаарх эрдэмтдийн үзэл хандлага

- ▶ 1. Өнгөний ерөнхий чиг хандлага (Universalist view) 1858-1969
- ▶ 2. Хэлний харьцангуйн онолын чиг хандлага (Relativist view) 1979-1983
- ▶ 3. Орчин цагийн судалгааны чиглэл

(Хүний хүчин зүйл: бие зүй, танин мэдэх үйл, сэтгэлгээний хэв шинж, хэлний баримт.

Бидний судалгаа энэ талаас юм.)

Өнөө үед шинжлэх ухааны олон салбар нэгдэх болсон онцлогтой. Энэ чиг хандлагын хүрээнд физикийн шинжлэх ухаан, сэтгэл судлал, тархи судлал, танин мэдэх үйл ажиллагааны онол, нийгэм хэлшинжлэл, хүний биезүй, хэлшинжлэлийн уулзвар дээр өнгө заасан нэрийн судалгаа хийх шаардлага гарч ирсэн.

Хэлшинжлэлийн судалгаа хийхэд дээрх шинжлэх ухааны салбарын онол, хандлага, судалгааны аргыг тооцох учиртай.

ӨНГӨ ТАНИХ БИЕЗҮЙН ҮНДЭС

1. Тархины танихуйн чадвар,
үүргийн онцлог, эрэгтэй,
эмэгтэй хүний тархи

2. Харааны биезүйн үндэс

НЭГДҮГЭЭР БҮЛГИЙН ДҮГНЭЛТ

Өнгө заасан нэрийн өнөө үеийн судалгаа хүн төвтэй, салбар хоорондын шинжтэй болж, өнгө таних, хүлээж авах, нэрлэх үйлийг хүн, түүний амьдрах орчин, танин мэдэх үйл, биезүй, сэтгэлзүйн олон талт шинж байдалтай холбон олон шинжлэх ухааны дүгнэлтийг харгалзан үзэж цогцоор судлах нь өнгө заасан нэр судлах шинэ чиг хандлага болох юм гэсэн дүгнэлтэд хүргэж байна. Энэ байдал бидний энэхүү судалгааны ажлын чиг хандлагыг тодорхойлсон болно.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

**ӨНГӨ ЗААСАН НЭРИЙН
ҮНДЭСНИЙ СЭТГЭЛГЭЭНИЙ
ОНЦЛОГ**

ХОЁРДУГААР БҮЛЭГ

*2.1. Хэл, соёлын шүтэлцээ сэтгэлгээний
хэв шинжийг тодорхойлох нь*

*2.2. Монгол, англи хэлний өнгө заасан нэр
үүсэх сэтгэлгээний онцлог*

*2.2.1. Өнгө заасан дан нэрээр илрэх
сэтгэлгээний онцлог*

2.2.2. Өнгө заасан нийлэмжээр

илрэх сэтгэлгээний онцлог

Монгол, англи хэлний өнгө заасан нэр vvcэх арга

№	Өнгө заасан нэр	Өнгө заасан нэр үүсэх арга	Жишээ (хоёр хэлэнд)	
1	Өнгө заасан дан нэр	Үндсээр өнгө заах дан нэр	<i>(хар, цагаан, улаан..., black, white, red...</i>	
		Өнгө заасан нэр+ бүтээвэр	<i>(шаравтар, ногоондуу... yellowish, greener, greenish...)</i>	
2	Өнгө заасан нийлэмж	Юм, үзэгдлийн шинж чанар заасан нэр + өнгө заасан нэр	Өнгө заасан нэр+өнгө заасан нэр	<i>(улаан хүрэн, хүрэн улаан, шар ногоон, улаан ягаан... reddish brown, brownish red, yellow green, reddish pink...)</i>
			өнгө илрэх шинж заасан нэр+ өнгө заасан нэр	<i>(хувхай цагаан, зэвхий цагаан, бүүдгэр цагаан..., pale white, dull white, pastel white)</i>
		Юм, үзэгдлийн нэр+ өнгө заасан нэр	<i>(усан цэнхэр, үүлэн цагаан, цасан цагаан..., ocean blue, cloud white, snow white...)</i>	
		Хүч нэмэгдүүлсэн үг+ өнгө заасан нэр	<i>(хав хар, цав цагаан, час улаан..., pitch black, very white, pure red...)</i>	

- ▶ Үндсэн өнгөний тухайд шинжлэх ухааны тайлбар болон ард түмний ойлголт ялгаатай байна:
- ▶ Спектрийн үндсэн долоон өнгө буюу монголчуудын солонгын 7 өнгө: *улаан, улбар шар, шар, ногоон, цэнхэр, хөх, нил ягаан*
- ▶ Монголчуудын үндсэн долоон өнгө: *хар, цагаан, улаан, ногоон, шар, хөх, цэнхэр*

*Үндсэн өнгө нэрлүүлэх туршилтад
ашигласан асуулгын хүснэгт*

/50 хүн/

Та үндсэн өнгө нэрлэнэ үү	Энэ юуны өнгө вэ?

Үндсэн өнгө нэрлүүлэх туршилтын үр дүн

№	Нэрлэсэн үндсэн өнгө	Хариулсан хүний тоо	Хувь	Юуны өнгө болох вэ	Хэдэн янзаар	Юуны өнгө болох тухай хамгийн их давтамжтай хариу
1	Хар	48	96%	хөөний өнгө 26, нүүрсний өнгө 7, муу муухай 4, харанхуйн өнгө 2, шөнө 1, ус 1, бүх өнгөний хаан 1, эцэг өнгө 1, мэдэхгүй 5	9	хөө
2	Цагаан	47	94%	сүү 39, цас 18, цагаан идээ 4	3	сүү, цас
3	Улаан	50	100%	цус 30, гал 19, жаргаж буй тэнгэрийн хаяа 1	3	цус, гал
4	Ногоон	50	100%	өвс ногоо 39, ургамал 7, зүлэг 4	3	өвс ногоо, ургамал
5	Шар	50	100%	алт 34, нар 15, нарны цацраг 1	3	алт, нар
6	Цэнхэр	47	94%	тэнгэрийн өнгө 43, ус 1, гол 1	3	тэнгэрийн өнгө
7	Хөх	47	94%	тэнгэр 17, хэлж мэдэхгүй 28	2	тэнгэрийн өнгө
8	Улбар шар	4	8%	хэлж мэдэхгүй 4	1	-
9	Нил ягаан	3	6%	бэхний өнгө 1, хэлж мэдэхгүй 2	2	-
10	Ягаан	2	4%	яргуй 1, мэдэхгүй 1	2	-
11	Хүрэн	2	4%	шороо 1, мэдэхгүй 1	2	-

Үндсэн өнгийн тайлбар (монгол, англи хэлний тайлбар толь бичгийн баримтаар)

№	Өнгө заасан нэр	Монгол хэлний тайлбар тольд тайлбарласан нь		Англи хэлний тайлбар тольд тайлбарласан нь	
		МХДТТ, 2008	МХТТТ, 1966	Oxford British [1] http://www.oxfordlearnersdictionaries.com/	Meriam Webster Dictionary, 2012
1	Цагаан White	Харын эсрэг өнгө, цас шиг өнгө;	Цас мэт өнгө;	having the colour of fresh snow or of milk;	Having the color of fresh snow or of milk;
2	Хар Black	Цагааны эсрэг, хөө, нүүрс зэргийн өнгө	Цагааны эсрэг, хөө, нүүрсний өнгө	having the very darkest colour, like coal or the sky at night	having the very darkest color of coal or the night sky
3	Улаан Red	Гал ба цус мэтийн өнгө	Цусны мэт өнгө;	having the colour of blood or fire	having the color of blood
4	Ногоон Green	Гандаагүй ногоо, навч, оюугийн өнгө:	Гандаагүй ногоо, навчны буюу оюугийн мэт өнгөтэй	having the colour of grass or the leaves of most plants and trees	having the color of growing grass
5	Шар Yellow	Алт мэт өнгө	Алт мэт өнгө	having the colour of lemons or butter	having the color of lemons or the sun
6	Хөх Blue	Номин чулууны адил өнгө:	Номин чулууны адил өнгө:	-	-
7	Цэнхэр Blue	Гүехэн хөх, тунгалаг тэнгэрийн өнгө	Цагаавтар хөх өнгө	having the colour of a clear sky or the sea/ocean on a clear day	having the color of a clear sky or the ocean on a clear day

**Монгол хэлний “өнгө заасан нэр+өнгө заасан нэр” загвараар нийлэмж
үүсэх чадамж**

	Саарал	Хүрэн	Ногоон	Ягаан	Бор	Хөх	Цэнхэр	Улаан	Цайвар	Цагаан	Хар	Шар	Буурал	Бараан	Нийт
Цайвар	+	+	+	+	+	+	+	+		+		+			10
Хар	+	+	+		+	+								+	6
Хүрэн	+			+	+	+		+							5
Хөх	+		+	+			+						+		5
Бараан			+		+	+					+				4
Цагаан	+			+					+						3
Бор	+	+	+		+										4
Улаан		+		+								+	+		2
Шар		+	+					+	+						4
Ногоон					+										1
Цэнхэр															0
Саарал		+	+												2
Ягаан		+													1
	6	7	7	5	6	4	2	3	2	1	1	2	2	1	<u>41</u>

**Монгол хэлний өнгө илрэх шинж заасан нэр + өнгө заасан нэртэй нийлэмж
үүсгэх чадамж**

	Саарал	Хүрэн	Ногоон	Ягаан	Бор	Хөх	Цэнхэр	Улаан	Цайвар	Цагаан	Хар	Шар	Буурал	Бараан	Нийт
Цайвар	+	+	+	+	+	+	+	+		+		+			10
Хар	+	+	+		+	+								+	6
Хүрэн	+			+	+	+		+							5
Хөх	+		+	+			+						+		5
Бараан			+		+	+					+				4
Цагаан	+			+					+						3
Бор	+	+	+		+										4
Улаан		+		+								+	+		2
Шар		+	+					+	+						4
Ногоон					+										1
Цэнхэр															0
Саарал		+	+												2
Ягаан		+													1
	6	7	7	5	6	4	2	3	2	1	1	2	2	1	<u>41</u>

“Юм, үзэгдлийн нэр + өнгө заасан нэр” загвар өнгө заасан нэр үүсэх танихуйн үндэс болох нь

№	Үүсэх арга	Монгол хэлэнд		Англи хэлэнд		Тайлбар
		Хэлэнд	Хувь	Хэлэнд	Хувь	
1	Байгалийн юм, үзэгдлийн нэр + өнгө заасан нэр	30	28,3%	35	20,3%	2 хэлэнд идэвхтэй
2	Хүн, мал, амьтны нэр, эд эрхтний нэр + өнгө заасан нэр	15	14,1%	13	7,5%	2 хэлэнд идэвхтэй
3	Эрдэнэсийн чулууны нэр + өнгө заасан нэр	15	14,1%	19	11%	2 хэлэнд идэвхтэй
4	Бодисын нэр + өнгө заасан нэр	13	12,2%	24	13,9%	2 хэлэнд идэвхтэй
5	Жимс, ногооны нэр + өнгө заасан нэр	13	12,2%	28	16,2%	2 хэлэнд идэвхтэй
6	Эд юмны нэр + өнгө заасан нэр	12	11,3%	20	11,6%	2 хэлэнд идэвхтэй
7	Хоол унд, хүнсний зүйлийн нэр + өнгө заасан нэр	7	6,6%	12	6,9%	2 хэлэнд идэвхтэй
8	Ажил, мэргэжлийн нэр + өнгө заасан нэр	1	0,9%	7	4%	2 хэлэнд идэвхтэй
9	Улс, газар орны нэр + өнгө заасан нэр	0	0%	14	8,1%	Монгол хэлэнд идэвхгүй
	Нийт	106	100%	172	100%	

ХОЁРДУГААР БҮЛГИЙН ДҮГНЭЛТ

Монгол, англи хоёр хэлний өнгө заасан нэрийн тогтолцоо дан нэгж болон өнгө заасан нийлэмжээс бүрдэж буй нь адил юм. Гагцхүү тэдгээрийн тоо ялгаатай, илэрхийлж байгаа утга, хэлбэр зарим талаар адил, зарим талаар ялгаатай байна.

Үндсэн өнгийн тухай ард түмний ойлголт шинжлэх ухааны ойлголтоос зөрөөтэй болохыг туршилтаар тогтоолоо. Үндсэн өнгийн тухай ард түмний ойлголт тухайн ард түмний ахуй амьдралд ойр дөт, нийтлэг өнгийн жагсаалт юм гэж дүгнэх боломжтой.

- ▶ Үндсэн өнгийн жагсаалтад багтсан өнгийн тайлбар хоёр хэлэнд зарим талаар дүйх боловч (хүн төрөлхтний нийтлэг туршлага), зарим талаар дүйхгүй байна.
- ▶ Хоёр хэлний баримтаас үзэхэд өнгө заасан дан нэрээс гадна өнгө заасан нийлэмж үүсэх ерөнхий загвар хоёр хэлэнд адил байна. Харин эдгээр загварын дотоод ангилал, ажиллах зарчим, нийлэмж үүсгэх чадамж ялгаатай байна.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

МОНГОЛ ХЭЛНИЙ ӨНГӨ
ЗААСАН НЭРИЙГ СЭТГЭЦ
ХЭЛШИНЖЛЭЛИЙН
АВАЛЦУУЛАН ХОЛБОХ АРГААР
СУДЛАХ НЬ

ГУРАВДУГААР БҮЛЭГ

3.1. Сэтгэц хэлшинжлэлийн авалцуулан

холбох арга

3.2. Монголчуудын өнгө заасан нэр үүсгэх

сэтгэлгээний хэв шинжийг тогтоох

туршилтын үр дүн:

дохио үг хариу үг загвар

3.3. Монгол хүний өнгө таних, нэрлэх
→

үйлдэлд хийсэн туршилтын үр дүн

дохио өнгө хариу үг загвар

→

Та дараах асуултад бүрэн хариулж бидний судалгаанд туслана уу?

1. Нас:
2. Хүйс:
3. Таны боловсрол:
4. Яс үндэс: 5. Эрхэлдэг ажил: 6. Таны төрсөн газар: 7. Таны оршин суугаа газар: 8. Хэдэн жил:
9. Та ямар гадаад хэл мэдэх вэ:
10. Гадаад улс, оронд амьдарч байсан эсэх: Тийм/Үгүй. Тийм бол хэдэн жил:

Та эдгээр өнгийг тодорхойлох хэдэн ч үг бичиж болно.

1. Цагаан-
2. Хар-
3. Улаан-.....
4. Шар -
5. Ногоон-
6. Цэнхэр-.....
7. Хөх -
8. Ягаан-
9. Бор -
10. Хүрэн -
11. Саарал -
12. Бусад өнгө -

Баярлалаа.

№	Дохио үг	Хариу үгийн тоо	Давтамжийн тоо
1	Шар	65	596
2	Цагаан	50	731
3	Хар	45	448
4	Ногоон	40	568
5	Улаан	32	506
6	Саарал	32	438
7	Ягаан	29	464
8	Цэнхэр	28	490
9	Хөх	28	448
10	Хүрэн	27	387
11	Бор	26	361
	Нийт	402	5437



№	Өнгө заасан нэр	16-25	26-35	36-45	46-57	56-74	Нийт
		87 хүн	73хүн	56 хүн	45 хүн	39 хүн	300хүн
1	Шар	194	160	131	58	53	596
2	Цагаан	258	145	147	112	69	731
3	Хар	133	100	106	67	42	448
4	Ногоон	187	130	113	70	68	568
5	Улаан	169	95	129	73	40	506
6	Саарал	128	115	102	49	44	438
7	Ягаан	126	112	113	48	65	464
8	Хөх	143	103	115	60	27	448
9	Цэнхэр	116	108	103	80	83	490
10	Хүрэн	94	92	100	55	46	387
11	Бор	124	104	71	33	29	361
		1672	1264	1230	705	566	5437

Өнгө заасан нэр үүсгэх сэтгэх арга ялгаатай болох нь

№	Өнгө заасан нэр үүсгэх сэтгэх арга	16-25	26-35	36-45	46-55	56-74
1	Юманд хамаатуулж өнгө заасан нэр үүсгэнэ.	29%	33%	34%	39%	38%
2	Өнгө заасан+ Өнгө заасан загвараар үүсгэнэ.	42%	29%	27%	31%	27%
3	Өнгөний тодлог шинж нэмэгдэх, буурах байдлыг зааж өнгө заасан нэр үүсгэнэ.	21%	17%	9%	7%	7%
4	Өнгөний шинж заасан үгтэй хамтарч өнгө заасан нэр үүсгэнэ.	8%	21%	30%	23%	28%

Дохио үг –хариу үг загвараар 11 өнгө заасан нэрд
эрэгтэй, эмэгтэй хүний ирүүлсэн хариу

№	Өнгө заасан нэр	Эрэгтэйчүүд 100%	Эмэгтэйчүүд 100%	Тайлбар
1	Цагаан	12%	11%	Эрэгтэйчүүдийн ирүүлсэн хариу үг их
2	Хар	11%	10%	
3	Бор	9%	8%	
4	Саарал	9%	8%	
5	Улаан	10%	11%	Эмэгтэйчүүдийн ирүүлсэн хариу үг их
6	Шар	8%	9%	
7	Ягаан	8%	9%	
8	Хүрэн	8%	9%	
9	Ногоон	9%	9%	Тэнцүү хариулсан
10	Цэнхэр	9%	9%	
11	Хөх	8%	8%	

Хариу үг —> дохио үг загвараар авсан туршилтын үр дүнг эргэн шалгах нь

Бид энэхүү туршилтанд оролцогчдын ирүүлсэн хариу үг монгол хэлний хамт олонд танил эсэх, ингэж нэрлэх зүй тогтол байгаа эсэхийг шалгах зорилгоор *шунхан улаан, элгэн улаан, гал улаан, цасан цагаан, сүүн цагаан, алтан шар, үнсэн саарал, нүүрсэн хар* гэх 8 хариу үг сонгон авч буцааж дохио үг болгон асуулга, аман ярианы баримт, уран зохиолын жишээгээр нягталлаа.

МОНГОЛ ХҮНИЙ ӨНГӨ ТАНИХ, НЭРЛЭХ ҮЙЛДЭЛД ХИЙСЭН ТУРШИЛТЫН ҮР ДҮН: ДОХИО ӨНГӨ ХАРИУ_ҮГ

Дохио өнгө хариу_үг загвараар монгол хүний өнгө таних, нэрлэх сэтгэлгээний хэв шинжийг харуулахад чиглэсэн.

Энэхүү туршилтад англи хэлний өнгөний нэрийн жагсаалтаас 81 өнгийг монгол хүнд өгч нэрлүүлж, бичүүлж авсан.

“ДОХИО ӨНГӨ—ХАРИУ ҮГ” загвараар хийсэн туршилтын асуулга

Та дараах асуултад бүрэн хариулж бидний судалгаанд туслана
уу?


1. Нас:
2. Хүйс:
3. Таны боловсрол:
4. Яс үндэс:
5. Эрхэлдэг ажил:
6. Таны төрсөн газар:
7. Таны оршин суугаа газар:
8. Хэдэн жил:
9. Та ямар гадаад хэл мэдэх вэ:
10. Гадаад улс, оронд амьдарч байсан эсэх: Тийм/Үгүй. Тийм бол хэдэн жил:
11. Та эдгээр өнгийг нэрлэнэ үү. Нэг өнгийн ард нэг хариу биш



Дохио өнгө → хариу үг насны байдлаар авч ҮЗСЭН НЬ

№	Хариу үг	18-25	26-40	41-64
		143/47,6%	94/31,3%	63/21%
1.	Үндсэн өнгийн нэрээр	+	+	+
2.	Өнгө заасан хоёр нэрээс нийлэмж үүсгэж	+	+	+
3.	Юманд хамаатуулж нэрлэсэн	+	+	+
4.	Өнги илрэх шинж заасан үгээр нэрлэсэн	+	+	+
5.	Өнгө заасан нийлэмжийг давхар тодотгосон	+	+	-
6.	Хүч нэмэгдүүлэх үг хамтатгасан	+	+	-
7.	Хүч сулруулсан шинж заасан үг хамтатгаж	+	+	-
8.	Тайлбар хийж	+	+	-
9.	Өнгөний физик шинжээр нэрлэсэн	+	+	-
10.	Бэлгэдлийн утгатай	+	+	+
11.	Өнгө буруу нэрлэсэн	+	+	-
12.	Нэрлэж мэдэхгүй гэж бичсэн, эсвэл хоосон зай үлдээсэн	+	+	+

Дохио өнгө → хариу үг туршилтын үр дүн хүйсээс хамаарах нь



ГУРАВДУГААР БҮЛГИЙН ДҮГНЭЛТ

“Дохио өнгө хариу ~~үг~~” туршилт монголчуудын өнгө таньж нэрлэх сэтгэлгээний хэв шинжийг тодорхойлоход чиглэсэн болно. Туршилтад оролцогчид 81 өнгө таниж нэрлэх даалгаварыг 84,7% биелүүлэв. Үлдсэн хувь нь санал болгосон өнгийн жагсаалтад танихгүй өнгө байна гэж дүгнэхэд хүргэж байна. Түүнээс гадна нэг өнгийг хамгийн багадаа 5 хувилбараар, хамгийн их нь 20 хувилбараар нэрлэснээс үзэхэд өнгө таних үйл хүний хүйс, нас, танихуйн туршлагаас ихээхэн хамаарч ялгаатай байна.

Нэг өнгөнд хамаатуулсан олон өнгө нэрлэж байгааг энэ өнгөтэй холбоотой танихуйн туршлага бага, нөгөө талаар, монголчуудын амьдралд энэ өнгө түгээмэл гэж тайлбарлах боломжтой.

Дээрхээс үзэхэд энэ гурван хүчин зүйл өнгө танихад нэн чухал болох нь харагдах ба нас, хүйсээр өнгө таних үйлийг нарийвчлан шалгасан үр дүн ч үүнийг давхар баталж буй. Тодруулбал, өнгө заасан нэр үүсгэх арга, загвар ялгаатай, үүсгэж байгаа өнгө заасан нэр ялгаатай, ирүүлсэн хариу тооны хувьд ялгаатай байна.

ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ

Хоёр хэлний өнгө заасан нэрийн зэрэгцүүлсэн судалгаа өнгө заасан нэр үүсэх сэтгэлгээний үндсэн арга хэлнээс хамаарахгүй адил, нийтлэг болохыг харуулж байна. Өнгө заасан дан нэрээс гадна өнгө заасан нийлэмж үүсэх ерөнхий загвар хоёр хэлэнд адил (“өнгө заасан нэр+өнгө заасан нэр”, “өнгө илрэх шинж заасан нэр+ өнгө заасан нэр” “юм үзэгдлийн нэр+ өнгө заасан нэр” загвар) байна.

Дотоод ангилалд буй аль нэг загвар нэг хэлэнд бүтээцтэй, идэвхтэй арга болох бол, нөгөө арга бүтээц багатай, мөн аль ард түмэн юунд хандаж ямар аргаар өнгө заасан нэр үүсгэж байгаа ялгаа нь амьдрах орчин, байгаль, газар зүйн онцлог, цаг уур, амьдралын хэв маяг ахуйн өвөрмөц байдал, соёл, танин мэдэх үйл, ард түмний танихуйн хамтын туршлага ба хувь хүний туршлага зэрэг хүчин зүйлээс хамаарна.

Толь бичиг, аман ярианы баримт, уран зохиолын жишээ болон сэтгэгц хэлшинжлэлийн авалцуулан холбох аргаар судалсны үр дүнд монгол хэлний өнгө заасан нэрийн сан, үүсэх сэтгэлгээний арга, загвар, өнгө заасан нэрийн тогтвортой хэрэглээ, нийлэмж үүсгэх хэв шинжийг тогтоолоо.

Хоёр хэлний өнгө заасан нэрийн зэрэгцүүлсэн судалгаа өнгө таних, өнгө нэрлэх үйл хүний тархины үйл ажиллагаа, харааны биезүй гэх биологийн хүчин зүйлээс гадна нас, хүйс, соёл, ахуй, орчин, танихуйн туршлага зэрэг нийгэм, соёлын хүчин зүйлээс хамаарна.

Судалгаанаас үзэхэд өнгө заасан нэр хүний сэтгэлгээний ерөнхий нийтлэг хэв шинжээс гадна үндэсний, хувь хүний сэтгэлгээний онцлог, эрэгтэй, эмэгтэй хүний болон насны ялгаанаас үүдэлтэй сэтгэлгээний онцлогийг харуулж байна.

**АНХААРАЛ ТАВЬСАНД
БАЯРЛАЛАА**